Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ НАНЗАДЫН НАНДИНЦЭЦЭГ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1.ТХШТХ-ийн 9.2.1 Хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлийн 10.6.1, 10.6.4, 10.6.5 кодтой хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж батлуулна. | Батлагдсан хяналтын хуудсын тоо | ЭМС-ын 2023 оны А/78 дугаар тушаал | Шинэчлэн боловсруулж ЭМС-ын тушаалаар батлуулсан байна. Шинэчлэх-3 | 10.6.1, 10.6.4, 10.6.5 кодтой хяналтын хуудсуудад нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/76 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан. | 2024.01.01-2024.02.24 | 100 |
| 2 | Арга хэмжээ 1.2. ТХШТХ-ийн 9.2.1 Хүнс хангамжийн төвийн эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудсыг шинээр боловсруулж батлуулна. | Батлагдсан хяналтын хуудсын тоо | - | Шинэчлэн боловсруулж ЭМС-ын тушаалаар батлуулсан байна. Шинээр-1 | 10.6.11 кодтой “Хүнс хангамж төвийн эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас”-ыг шинээр боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/76 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан | 2024.01.01-2024.02.24 | 100 |
| **Зорилт 2. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Арга хэмжээ 2.1. ТХШТХ-ийн $5^2$.1<br>Хүүхэд, өсвөр үеийн чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсролын сургалтын байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулна. | Объектын хамралтын хувь | 85.8% | ~~40%~~ 100% | Эрүүл мэндийн салбарын 2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтын объектын жагсаалтад хүүхэд өсвөр үеийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр аймаг, нийслэлийн нийт 333 объектыг нэгтгэн боловсруулж, батлуулсан.<br>БШУЯ, ЭМЯ-ны хамтарсан 03-00/03 дугаартай удирдамжийн хүрээнд хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй, халдвар хамгааллын чиглэлээр 342 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, шалгалтад хамрагдсан объектуудын хамралт 98.8 хувьтай байна. | 2024.01-2024.12 | 100<br>91% |
| | | | | | Хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй, халдвар хамгааллын чиглэлээр аймаг, нийслэлийн 342 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн. Тодорхой шалтгааны улмаас 4 объект шалгалтад хамрагдаагүй. | | |
| | | Эрсдэлийн түвшин хувь | Их 10.1% | - | Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан сургууль, цэцэрлэг, дотуур байр, их, дээд сургуулийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын хуудсаар эрсдэлийн түвшин 131 буюу 38.3% нь "бага эрсдэлтэй", 173 буюу 50.6% нь "дунд эрсдэлтэй", 38 буюу 11.1% нь "их эрсдэлтэй" үнэлэгдсэн ба эрсдэл үүсэх магадлал 34.05% байна.<br>Хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр 2024 онд улсын хэмжээнд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хийгдсэн хяналт шалгалтын явцад нийт 6120 зөрчил илрүүлж, газар дээр нь 53.7%-ийг арилгуулж, нийт 109 объектын эрсдэлийн түвшин буурсан байна. | | |
| | | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | 59.6% | 20% | Төлөвлөгөөт хяналт шалгалтын хууль тогтоомжийн хэрэгжилт 66.7% байна. Хяналтын хуудсын бүлгээр тавигдах шаардлагын хэрэгжилтийг авч үзвэл гадна орчин, барилга байгууламжид тавигдах шаардлагын хэрэгжилт 53.2%, усан хангамж, ариун цэврийн байгууламжид тавигдах шаардлагын хэрэгжилт 77.9%, анги танхимын эрүүл ахуйн шаардлагын хэрэгжилт 71.7%, хүүхдийн эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт 67.8%, үдийн хоол, хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой шаардлагын хэрэгжилт 58.5%, дотоод хяналтын үйл ажиллагаа 57.7%-тай байна. | | |
| | Дэд арга хэмжээ 2.1.1. Төлөвлөгөөт шалгалтын явцын, жилийн эцсийн дүн мэдээг аймаг, нийслэлээс авч нэгдсэн мэдээ, танилцуулга боловсруулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 40% | Хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр 2024 онд улсын хэмжээнд хийгдсэн хяналт шалгалтын явцад нийт 6120 зөрчил илрүүлж, газар дээр нь 53.7%-ийг арилгуулж, нийт 109 объектын эрсдэлийн түвшин буурсан байна. Нийтлэг илэрч буй зөрчлийн төрлөөр нь авч үзвэл "барилга байгууламжийг шинээр барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөн засварлахдаа холбогдох хяналтын | 2024.01-2024.12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулсан байх шаардлага-ыг 57.1%, “эдэлбэр газрын хөрс нь аюулгүй үзүүлэлтийн шаардлагыг хангасан, жилд 1 удаа итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлсэн байх шаардлага”-ыг 71.4-80.8%, “гадна тоглоомын болон биеийн тамирын талбайг хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байх шаардлага”-ыг 54.8%, “хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд төлөвлөлт хийж ашиглах шаардлага”-ыг 78.5-84.1%, боловсролын сургалтын байгууллагын анги танхимын хүрэлцээ хангамж, тавигдах шаардлагыг 57.8-61.2%, кабинетуудад тавигдах шаардлагыг 53.8-71.8%, халдвар хамгааллын дэглэмийн шаардлагыг хангасан | | |
| | | | | | тусгаарлах өрөөтэй, ашигладаг байх шаардлагыг 72.5%, хүүхдийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхлэхийн өмнө хяналтын байгууллагаар урьдчилсан хяналт хийлгэж дүгнэлт гаргуулсан байх шаардлагыг 50.29%, Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтөлдөг, хоол, хүнснээс шалтгаалсан хордлого, халдвар гарсан тохиолдолд бүртгэлийг ашигладаг байх шаардлага”-ыг 60.0-88.9%, “ундны ус нь стандарт, аюулгүй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байдлын шаардлага хангасан байх, хэсгийн ус хангамжийн эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоох, дэглэмийг мөрддөг байх шаардлага"-ыг 66.7%, "хортон шавж, мэрэгчийн устгал, халдваргүйжүүлэлтийг улирал тутам тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгуулагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлдэг байх шаардлага"-ыг 73.3% нь тус тус хангаагүй байна. | | |
| 4 | Дэд арга хэмжээ 2.2. Сүхбаатар аймагт зарлагдсан дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсролын сургалтын байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийнэ. | Объектын хамралтын хувь | - | 100% | Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Эрдэнэцагаан, Сүхбаатар, сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 3 сургууль, 3 цэцэрлэг, нийт 6 байгууллагад төлөвлөгөөт шалгалт хийсэн. Холбогдох хяналтын хуудасны дагуу үнэлгээ хийхэд 6 байгууллага бага эрсдэлтэй үнэлэгдсэн.<br>Шалгалтын явцад илэрсэн дутагдлыг арилгуулах зорилгоор Сүхбаатар аймгийн Засаг даргад 6 заалт бүхий улсын ахлах байцаагчийн хамтарсан албан шаардлагаар мөн 1 сургууль, 1 цэцэрлэгт нийт 14 заалт бүхий улсын ахлах байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилт 35.7%-тай байна. | 2024.04.29-2024.05.06 | 100 |
| | Дэд арга хэмжээ 2.2.1. Хяналт шалгалтын хамтарсан удирдамж боловсруулж батлуулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 20% | "Төлөвлөгөөт шалгалт хийх тухай" 10-00/42 дугаартай удирдамж боловсруулж батлуулсан. | 2024.04.22 | 20 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Дэд арга хэмжээ 2.2.2. Төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, дүнг нэгтгэн, танилцуулга боловсруулж, удирдлагад танилцуулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 80% | Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, Боловсрол соёлын газрын Боловсролын хяналтын улсын байцаагч, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн удирдлагыг байлцуулан аймгийн Засаг даргын орлогч, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдын удирдлага, эмч, хоол зүйч, арга зүйч, багш, ажилтанд урьдчилсан байдлаар шалгалтын нэгдсэн дүнг танилцуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хууль тогтоомж, стандартын шаардлага хангуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>Төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн тухай танилцуулгыг үйлдэж, газрын даргад танилцуулсан. | 2024.05 | 80 |
| 5 | Арга хэмжээ 2.3. Сургалтын боловсролын байгууллагын барилга байгууламж барих газрын байршил тогтоох, зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилан хяналт шалгалт хийнэ. | Шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | "Барилга байгууламжийг барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалт хийх тухай 10-00/02 дугаартай удирдамжийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтээр сургалтын боловсролын байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл хянах чиглэлээр тайлант хугацаанд 21 хүсэлтийн дагуу эрүүл ахуйн хяналт хийж, шаардлага хангаагүй 1 байгууллагат албан бичгээр, шаардлага хангасан 20 байгууллагат улсын ахлах байцаагчийн дүгнэлтээр хариуг өгч шийдвэрлэсэн. | 2024.01-2024.12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Мөн хугацаанд аймагт 162, нийслэлд 51 нийт 213 хүсэлтийн дагуу эрүүл ахуйн хяналт хийж, шаардлага хангаагүй 9 байгууллагад албан бичгээр, шаардлага хангасан 167 байгууллагат улсын (ахлах) байцаагчийн дүгнэлтээр хариуг өгч шийдвэрлэсэн байна.<br>Сургалтын боловсролын байгууллагын 37 барилга байгууламжийг шинээр ашиглалтад оруулах улсын комисст оролцож, 27 барилгыг ашиглалтад оруулахаар шийдвэрлэж, эрүүл ахуйн нөхцөл шаардлага хангаагүй, үүрэг даалгаврыг бүрэн биелүүлээгүй 10 барилгыг ашиглалтад аваагүй, үүрэг даалгавар өгч ажилласан. | | |
| 6 | Арга хэмжээ 2.4.<br>Бүх шатны боловсролын сургалтын байгууллагуудын 2024-2025 хичээлийн жилийн бэлтгэл, үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ. | Хамруулсан объектын тоо | 661 | 670 | Улсын хэмжээнд 289 цэцэрлэг, 217 ерөнхий боловсролын сургууль, 55 дотуур байр, 61 сургуулийн үдийн хоол хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгж, 13 хүнсний бүтээгдэхүүн ханган нийлүүлэгч, нийт 635 объектыг хамруулан хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтад улсын хэмжээнд 700 боловсролын сургалтын байгууллага хамрагдахаас 635 буюу 90.7 хувьтай хамрагдсан байгаа нь барилгын засвар хугацаандаа эхлээгүйгээс бүрэн дуусаагүй, хичээлийн сургалтын үйл ажиллагаа цахимаар хичээлсэн, Боловсролын яам, ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын | 2024.09<br>94.7. | 98.2. |
| | | Зөрчил арилгуулалтын хувь | 60.2% | 63.9 | | | |
| | | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | 53.2% | 60 | | | |

75

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газрын улсын байцаагчидтай хамтран хийхээр төлөвлөгдсөн байгууллагуудад хийх хяналт яамдын шилжилт хөдөлгөөний ажлаас үүдэлтэйгээр цалгардаж нэг нэгнээ хүлээж хугацаа алдсан, зарим сургуулиуд элсэлт аваагүй зэрэг шалтгаантай холбоотой байна.Шалгалтын явцад нийт 2160 зөрчил илрүүлж, 63.9%-ийг газар дээр арилгуулсан нь өмнөх оны үзүүлэлтээс 3.7 хувиар өссөн. Зөрчил дутагдлыг арилгуулахаар 59 байгууллагад 350 заалттай албан шаардлага, 70 байгууллагад 949 заалттай зөвлөмж хүргүүлж, 37 байгууллагад 73 заалттай акт, 122 дүгнэлт үйлдсэн. Зөрчил үйлдсэн үдийн хоол хөтөлбөр хэрэгжүүлэгч 2 байгууллага, аж ахуйн нэгжид 1500.0 мянган төгрөгийн торгуулийг хялбаршуулсан журмаар ногдуулж 100 хувь барагдуулсан. Хууль тогтоомжийн хэрэгжилт 56.5 хувьтай байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 3.3 хувиар нэмэгдсэн байна. | | |
| | Дэд арга хэмжээ 2.4.1. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамж боловсруулж батлуулна. | Батлагдсан удирдамж | - | 100% | “Бүх шатны боловсролын сургалтын байгууллагуудын 2024-2025 оны хичээлийн жилийн бэлтгэл, үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамж” боловсруулж, Боловсрол, шинжлэх ухааны яаманд хүргүүлэн саналаа тусгуулан батлуулсан. 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 10-00/31 дугаартай удирдамжийг | 2024.09 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн. | | |
| | Дэд арга хэмжээ 2.4.2. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын хяналт шалгалтын нэгжээс ирүүлсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэж, удирдлагад танилцуулж, шалгалтын нэгдсэн дүн мэдээг Боловсрол шинжлэх ухааны яамны Салбарын хяналтын газарт хүргүүлнэ. | Нэгдсэн танилцуулга | - | - | Батлагдсан удирдамжийн дагуу шалгалт хийж, шалгалтын танилцуулгыг байгууллагын удирдлагад танилцуулсан. | 2024.09 | |
| 7 | Арга хэмжээ 2.5.<br>Өдөр өнжүүлэх бүлгийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ. | Объектын хамралтын тоо | 223 | 250 | Хяналт шалгалтад улсын хэмжээнд 230 өдөр өнжүүлэх бүлэг хамрагдахаас **37 буюу** 16.1 хувьтай хамрагдсан. 17 аймагт өдөр өнжүүлэх бүлэг ажиллуулж байсан бүртгэлтэй байгууллага, аж ахуйн нэгж, иргэн эдийн засгийн боломжгүй байдлаас үйл ажиллагаагаа зогсоосон байна. Шалгалтын явцад нийт **132 зөрчил илрүүлж,** 62.1 хувийг газар дээр арилгуулсан ба зөрчил дутагдлыг арилгуулахаар 2 байгууллагад 12 заалттай албан шаардлага хүргүүлж, биелэлтэд нь хяналт тавин ажиллаж, албан шаардлагын гүйцэтгэл 66.7 хувийн хэрэгжилтттэй, хууль тогтоомжийн хэрэгжилт 64.4 **хувьтай байгаа нь** өмнөх оны үзүүлэлтийн түвшинд байна. | 2024.01-2024.10 | |
| | | Зөрчил арилгуулалтын хувь | 28% | 35 | | | |
| | | | | | | | |
| | | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | 64.7% | 64,4 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | БСШУС-ын 2021.12.03-ны өдрийн А/417 дугаар тушаалын хавсралтаар “Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлага” эрх зүйн актыг хүчингүй болж, хүүхдийн эрх хамгаалал зөрчигдөх эрсдэлтэй байна. | | |
| | Дэд арга хэмжээ 2.5.1. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамж боловсруулж батлуулна. | Батлагдсан удирдамж | - | 100% | Өдөр өнжүүлэх бүлгийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 10-00/31 дугаартай удирдамж боловсруулж, салбарын хяналтын газрын даргаар батлуулсан. Батлагдсан удирдамжийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн. | 2024.10 | 100 |
| | Дэд арга хэмжээ 2.5.2. Хяналт шалгалтын дүнг нэгтгэж, удирдлагад танилцуулна. | Нэгдсэн танилцуулга | - | 20% | Батлагдсан удирдамжийн дагуу шалгалт хийж, шалгалтын танилцуулгыг байгууллагын удирдлагад танилцуулсан. | | 20 |
| 8 | Арга хэмжээ 2.6. Ундны усны чанар аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын хүүхэд, өсвөр үеийн чиглэлийн объектын ундны усны лабораторийн шинжилгээний дүн мэдээг нэгтгэж, удирдлагад танилцуулна. | Шинжилсэн дээжийн тоо | 644 | 260 | Салбарын хяналтын газрын даргын баталсан 2024 оны 10-00/20 дугаартай удирдамжийн дагуу аймаг, нийслэлийн төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн нийт 601 объектоос усны дээж авч, ХАБҮЛЛ, Стандарт, хэмжилзүйн газрын Нийслэлийн лаборатори, аймгууд дахь Стандарт, хэмжилзүйн хэлтсийн харьяа лабораторид нян судлал, химийн үзүүлэлтээр шинжлүүлэн үнэлгээ өгөв. Шинжлэгдсэн нийт дээжийн 111 дээж буюу 18.5 хувь нь стандартын шаардлага хангаагүй дүнтэй | 2024.01-2024.12 | 100 |
| | | Стандартын шаардлага хангаагүй дээжийн хувь/нян судлал | 7.3% | 7% | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шинжлэгдсэн. Хяналт шалгалтын явцад унд ахуйн усны чанар, аюулгүй байдалд хийсэн шинжилгээний дүнг үндэслэн улсын (ахлах) байцаагчийн 10 дүгнэлт үйлдэж, шалгагдсан байгууллага, аж ахуйн нэгжид хүргүүлсэн. | | |
| 9 | Арга хэмжээ 2.7.<br>Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийнэ. | Шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | 2024 онд ирсэн 6 албан бичиг хүлээн авч, танилцан албан бичгийн хариуг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэсэн.<br>Аймаг, нийслэлийн Боловсролын сургалтын байгууллагад иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн Удирдах дээд байгууллагын шийдвэр, өргөдөл гомдлын дагуу 35 объектод төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгдэж, хугацаанд нь шийдвэрлэсэн. Шалгалтын явцад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар улсын (ахлах) байцаагчийн 50 заалт бүхий 7 зөвлөмж, 265 заалт бүхий 34 албан шаардлага үйлдэж, холбогдох газруудад нь хүргүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтэнд хяналт тавин ажиллаж, гүйцэтгэлийн хяналтыг 64 объектод хийж, зөрчил гаргасан 6 байгууллагад 4900,0 мянган төгрөгний торгууль ногдуулж, 49%-ийг бүрэн барагдуулан ажиллаж байна. | 2024.01-2024.12 | 100 |
| | | | | | Эрүүл мэндийн байгууллага, боловсрол сургалтын байгууллагуудтай холбоотой | 2024.01-2024.12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамтарсан тушаал, журам, норм дүрэм, санамж бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт, хөтөлбөр зэрэг эрх зүйн бичиг баримтын шинэчилсэн 4 төсөлд нийт 9 санал боловсруулж хүргүүлсэн. | | |
| | | | | | Нийслэлийн эрүүл мэндийн газраас ирүүлсэн мэдээллийн дагуу Баянзүрх дүүргийн 12 дугаар хороонд байрлах нийслэлийн 147 дугаар ерөнхий боловсролын сургуульд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан хийсэн хяналт шалгалтын дүн мэдээ, тандалт судалгааг 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 04 дүгээр сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ. 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар Нийслэлийн 147 дугаар ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаа хэвийн явагдаж эхэлсэн, шалгалтын нэгдсэн дүн мэдээг нэгтгэн удирдлагад танилцуулсан | 2024.04.17-2024.04.22 | |
| | | | | | Эрүүл мэндийн сайдын баталсан "Ажлын хэсэг байгуулах тухай" 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/124 тоот тушаалын хүрээнд хүн амын дунд шүд цоорох өвчний урьдчилан сэргийлэлтийн тогтолцоог бий болгох, эрүүл зан үйлийг багаас нь төлөвшүүлэх Эрүүл шүд төслийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж байна. | 2024.01-2024.12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Яамны албан хаагчдын хүүхдүүдийг “Эрүүл шүд” урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулсан. “Эрүүл шүд” урьдчилан сэргийлэх үзлэгийг Шүд, эрүү нүүрний төвд хийж, үзлэгт нийт 65 хүүхэд хамрагдан шүдээ эрүүлжүүлсэн. | | |
| | | | | | ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2023.08.31-ний өдрийн А/110 дугаартай “Эцэг, эхийн зөвлөл байгуулах” тухай тушаалд тусгагдсан Эцэг, эхийн зөвлөлийн ажлын хэсэгт оролцож, яамны албан хаагчдаас авсан асуумж судалгааг нэгтгэн, албан хаагчид тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг Монгол-Японы хамтарсан эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэгт тус тус зохион байгуулж ажиллалаа.<br>“Эрүүл монгол хүүхэд” гар зургийн уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг нэгтгэн 2024 оны календарь хийлгүүлэн, яамны албан хаагчдад гардуулж өглөө.<br>Яамны албан хаагчид тэдгээрийн гэр бүл, үр хүүхдүүдийг Үндэсний өв соёл, эх түүхээ танилцуулах зорилгоор соёлын салбарын томоохон бүтээн байгуулалт бүхий Чингис хаан Үндэсний музейг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр үзүүлэх арга | 2024.01-2024.12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэмжээг зохион байгуулан ажилласан. | | |
| | | | | | ЭМЯ, МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан Олон улсын эмч нарын өдөрт зориулсан “Эмч танаараа бахарья 2024” арга хэмжээ мөн Олон улсын сувилагчдын өдөрт зориулсан “Сувилагч танаараа бахархъя 2024” арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтын ажлын хэсэгт оролцож ажилласан. Танхимаар болон цахимаар 13 сургалтад хамрагдаж, 2 зөвөлгөөн, 1 чуулганд оролцсон. | 2024.05 | |
| **Зорилт 3. Хяналт шалгалтын ил тод, тэгш байдлыг хангаж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | |
| 10 | Арга хэмжээ 3.1. “Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг хангах” сэдэвт сургалтыг зохион байгуулна. | Сургалтын тайлан | 2023 онд сургалт зохион байгуулсан | - | Сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу 2024.08.22-ны өдөр цахим хэлбэрээр Эрүүл мэндийн яамны 306 тоот өрөөнд зохион байгуулж, аймаг, нийслэлийн ЭМГ-ын хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуйн асуудал хариуцсан эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчид, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага, хоол хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгж, иргэд нийт 174 хүн хамрагдав.Аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй бүх шатны боловсролын сургалтын | 2024.08 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагуудын 2024-2025 оны хичээлийн жилийн бэлтгэл, үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой, мэдээллийг хүртээмжтэй түгээсэн, үр дүнтэй сургалт боллоо гэж сургалтад оролцогчид үнэллээ. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 1. Мэргэжлийн мэдлэгээ дээшлүүлэх, чадавхижуулах сургалтад хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоо | - | - | Мянганы сорилтын сангаас зохион байгуулсан Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх гарын авлага боловсруулах зөвлөх үйлчилгээ "Сургагч багш" бэлтгэх сургалт хамрагдаж, сертификат авсан.<br>ЗГХЭГ-аас зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн хөгжил, хамгаалал хэлэлцүүлэг, сургалт" хамрагдсан. | 2024.04.25, 2024.05.27 | 100 |
| 2 | Арга хэмжээ 2. Стандарт, хэмжил зүйн газрын Баталгаажуулалтын шинжээчийн эрх олгох сургалт M2, M3, M4 хамрагдана. | Баталгаажуулалтын гэрчилгээ авсан байна. | - | - | - Баталгаажуулалтын шинжээчийн эрх олгох сургалтад хамрагдахаар бүртгүүлэх гэсэн боловч тус сургалтад чиглэлийн мэргэжилээр ажиллаж буй төрийн захиргааны | 2024.04-2024.12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагад ажиллаж буй улсын байцаагчийг хамруулах шаардлагагүй гэсэн тул Дэлхийн Банкнаас зохион байгуулсан Азийн бүтээмжийн байгууллагын “Хүнсээр дамждаг эмгэг төрүүлэгчийн эрсдэлийн удирдлага” цахим сургалтад хамрагдсан. | | |
| 3 | Арга хэмжээ 3. Мэргэжлийн мэдлэгээ дээшлүүлэх, чадавхижуулах сургалтад хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоо | - | - | БНХАУ-ын Чанжоу хотын Жянсу хяналт шалгалт, хорио цээрийн чанарын хүрээлэнгээс зохион байгуулсан “Хөгжиж буй орнуудын албан тушаалтануудад зориулсан Боомтод нийгмийн эрүүл мэндийн тогтолцооны бүтээн байгуулалт” сэдэвт сургалтад хамрагдсан. БНХАУ-ын Худалдааны яамнаас 24A4021021 дугаартай гэрчилгээ олгосон. | 2024.09.12-2024.09.25 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ................................ /Н.НАНДИНЦЭЦЭГ/ 2024.12.05

*(Албан тушаал)* *(Нэр, гарын үсэг)* *(Огноо)*